



МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

1998 оны 11 дугаар
сарын 12 өдөр

Дугаар 6-198

Улаанбаатар
хот

"Гэгээ" улсын үйлдвэрийн газрын
дүрэм батлах тухай

Нэг. Улаанбаатар хотын "Гэгээ" улсын үйлдвэрийн газрын дүрмийг хавсралт ёсоор баталсугай.

Хоёр. Энэхүү дүрэмд нийцүүлж байгууллагын бүтэц зохион байгуулалтыг шинэчлэн боловсруулж, Захирагчийн ажлын албатай зөвшилцөн шийдвэрлэхийг "Гэгээ" компаний захирал (Х.Бүрэнтогтох)-д даалгасугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

Ж.НАРАНЦАЦРАЛТ

Нийслэлийн Засаг даргын 1998 оны
6-р сар 10-ны өдөр захирамжийн хавсралт

УЛААНБААТАР ХОТЫН "ГЭГЭЭ" УЛСЫН ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Хуулийн этгээд болох гадаадын харъяат иргэдэд үйлчлэх газар нь гадаадын иргэдэд байр түрээслүүлэх, худалдаа үйлчилгээ болон бусад аж ахуйн чанартай үйл ажиллагааг явуулж, санхүү болон үйл ажиллагааны хувьд нэгдсэн зохион байгуулалтанд орж Монгол улсын Иргэний хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нөхөрлөл компанийн хуулийн дагуу төрийн өмчид үндэслэгдэн байгуулагдсан компани (Улсын үйлдвэрийн газар) хэлбэрээр ажиллана.

1.2. Газрын оноосон нэр нь "Гэгээ" бөгөөд төв нь (цаашид энэ дүрмэнд компани гэнэ) Улаанбаатар хотод байрлана.

1.3. "Гэгээ" компани нь Чингэлтэй дүүргийн 3 дугаар хороо, II-40,0-тын 8 дугаар байранд байрлана. Утас 312029, факс 976-1-312169

1.4. Компани нь өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээд мөн.

1.5. Компанийн дүрмийн сан	550727,1 сая төгрөг
Үндсэн хөрөнгө	553654,9 сая төгрөг
Эргэлтийн хөрөнгө	105310,1 сая төгрөг

Хоёр. Компанийн үйл ажиллагааны эрх хэмжээ

2.1. Компанийг байгуулах тухай шийдвэр гарсан өдрөөс байгуулагдсанд тооцож Нөхөрлөл компанийн хуулинд заасан журмаар бүртгүүлж хуулийн этгээдийн эрхтэй болно.

2.2. Компани нь өөрийн нэрийн өмнөөс гадаад дотоодын байгууллагатай эрх зүйн харилцаанд орох, эд хөрөнгийн ба эд хөрөнгийн бус эрх эдлэх, үүрэг хүлээх, түүнчлэн шүүх, арбитрийн байгууллагад нэхэмжлэгч буюу хариуцагчаар оролцох эрхтэй.

2.3. Компани нь өөрийн салбар нэгж байгуулан ажиллуулж болно.

2.4. Компани өөрийн тамга, тэмдэг, бичгийн хэвлэмэл хуудастай байна. Салбар нэгж байгууллага нь үйл ажиллагааны цар хүрээнээс хамаарч өөрийн тамга, тэмдэг, бичгийн хэвлэмэл хуудастай байж болно. Үүнийг компанийн захирлын зөвлөлийн хурлаар шийднэ.

2.5. Ашиглалт, засварын түүхий эд, материал, тоног төхөөрөмжийг гадаад, дотоодын зах зээлээс бие даан бэлтгэнэ.

2.6. Компани нь дараах хөрөнгийн эрх үүрэгтэй.

а/ Өөрийн эд хөрөнгийн бүрэн байдлыг хангаж үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн эзэмшиж ашиглах.

б/ Үндсэн хөрөнгийг холбогдох хууль тогтоомжид заасан эрх хэмжээнийхээ дотор захиран зарцуулах.

в/ Ажил үйлчилгээ үзүүлсний үр дүнд олсон ашгийг эрх бүхий байгууллагаас тогтоосон нормативт хэмжээгээр үлдээж холбогдох хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах.

2.7. Компани нь дор дурьдсан үйл ажиллагааг явуулна.

а/ Монгол улсад урилгаар болон томилолтоор ажиллаж байгаа гадаадын иргэдэд байр түрээслүүлж, төвиглэ эд хопшпоор төлбөртэй үйлчлэн тэдгээр иргэдийн оршин суух нөхцлийг бүрдүүлэхэд ажлаа чиглүүлнэ.

б/ Гадаадын иргэний монголд байх хугацааг харгалзан орон сууцны түрээслэх буюу зочид буудлын тарифаар үйлчлэх гэрээ байгуулна.

в/ Монголын талаас гадаадын иргэнийг урьж ирүүлсэн байгууллага нь "Гэгээ" компанийн гэрээ, дүрмэнд заагдсаны дагуу гэрээ байгуулж, гэрээний дагуу үйлчлүүлнэ.

г/ Гадаадын харъяат байр түрээслэгч иргэн нь түрээсийн гэрээг компанитай өөрөө байгуулж, төлбөрийг өөрийн биеэр хийнэ.

д/ Үйлчилгээний журмыг түрээслэгч, түрээслүүлэгчийн эрх бүхий хүмүүс (хэсгийн дарга нар) бүрэн биелүүлэх үүрэгтэй.

Гурав Компанийг үүсгэн байгуулагчийн эрх

3.1. Компанийг үүсгэн байгуулагч нь Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч байна.

3.2. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч компанийн захирлыг томилж ажлаас чөлөөлнө.

Дөрөв. Компанийн захирлын эрх хэмжээ

4.1. Компанийн захирал нь үйл ажиллагаагаа гүйцэтгэн явуулахад захирлын зөвлөлтэй байх болно.

4.2. Захирлын зөвлөл нь гурваас доошгүй гишүүнтэй байна.

4.3. Тухайн асуудлыг шийдэхдээ зөвлөлийн олонхийн саналыг харгалзаж захирал шийдвэр гаргана.

4.4. Компанийн эдийн засаг, бизнесийн төлөвлөгөөг зөвлөлөөр оруулан хянуулж захирал батлана.

4.5. Компанийн зохион байгуулалтын бүтэц, ажиллагсдын цалин хэмжээ, урамшууллын журмыг Захирагчийн ажлын албатай зөвшилцөн тогтооно.

4.6. Захирлын зөвлөлийн хурал нь 7-10 хоногт нэгээс доошгүй хуралдана.

4.7. Компанийн хэмжээнд мөрдөн ажиллах байгууллагын дотоод журмыг захирлын зөвлөлөөр хэлэлцэж захирлын тушаалаар батлана.

4.8. Захирал нь ажилтныг ажилд авах, чөлөөлөх, сахилгын арга хэмжээ авах, тэдний цалинг тогтоох зэргийг зөвлөлөөр шийдвэрлүүлж болно.

Тав. Компанийн захирлын үүрэг

5.1. Захирал нь энэ дүрэм болон гэрээнд заасан хугацаанд тогтоож өгсөн эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдана.

5.2. Захирал нь Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч болон Захирагчийн ажлын албаны өмнө ажлаа тайлагнана.

5.3. Захирал зөвлөлийн хурал хуралдуулах тухай саналыг гаргаж болно.

5.4. Компанийг гадаад, дотоодын бүрэн эрхтэйгээр чөлөөлөх, бусдад итгэмжлэл олгох.

5.5. Компанийн нэрийн өмнөөс эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомж, гэрээнд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулах.

5.6. Тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж байгаа байдал, нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулах.

5.7. Мэргэантай асуудлаар компаниа төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргах ба хууль хяналтын байгууллагад хандах.

5.8. Эрх хэмжээнийхээ хүрээнд компанийн хэмжээнд дагаж мөрдөх тушаал гаргах.

5.9. Монгол улсын холбогдох хууль тогтоомжид заасан бусад үүрэг хүлээнэ.

Зургаа. Санхүү бүртгэл

6.1. Санхүү бүртгэлийн систем нь Монгол улсын холбогдох хууль, тогтоомж, түүнд орсон өөрчлөлтийн дагуу явагдана.

6.2. Компанийн санхүүгийн жил нь тухайн оны 1 дүгээр сарын 1-нээс эхэлж, 12 дугаар сарын 31-ний өдөр дуусна. Санхүүгийн анхны жил нь компани байгуулагдсан өдрөөс эхлэж хуанлийн жилийн 12 дугаар сарын 31-ний өдөр дуусах ба санхүүгийн жил нь компанийг татан буулгасан өдрөөр дууссанд тооцно.

6.3. Компани нь Монгол улсын хууль тогтоомжийн дагуу орлогын болон бусад татвар хураамжийг төлнө.

6.4. Компани нь анхан шатны бүртгэлийн баталгаажсан баримтыг үндэслэн дэлгэрэнгүй ба хураангуй бүртгэл хөтлөн, тайлан тэнцлийг улирлаар гаргаж, Татварын алба, санхүүгийн байгууллагад тушаана.

6.5. Компани нь Монгол улсын хууль тогтоомжийн дагуу хөрөнгийн элэгдэл хорогдлын шимтгэлийг тооцно.

6.6. Компанийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавих үүргийг хууль тогтоомжид заасан байгууллага хэрэгжүүлнэ.

6.7. Компанийн тооцоо, тайлангийн мөнгөн дүнг төгрөгөөр илэрхийлнэ.

Долоо. Санхүүгийн хяналт

7.1. Компанийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, эзэмшилт, ашиглалт, захиран зарцуулалтанд эрх бүхий байгууллагуудаар хяналт шалгалтыг холбогдох хуулийн дагуу хийлгэнэ.

7.2. Компанийн аж ахуй, санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтын мөрөөр шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

Найм. Татан буулгах

8.1. Компанийг татан буулгах шийдвэрийг үүсгэн байгуулагч хуульд заасан үндэслэлээр гаргана.

8.2. Компанийг татан буулгах тохиолдолд үүсгэн байгуулагчаас томилсон комисс татан буулгах ажлыг эрхлэнэ.

Ес. Бусад зүйл

9.1. Энэхүү дүрэмд оруулсан нэмэлт өөрчлөлтийг тухай бүр Монгол улсын бүртгэлийн болон эрх бүхий байгууллагад мэдэгдэж бүртгүүлнэ.

9.2. Энэхүү дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд тэдгээр нь дүрмийн зайлшгүй хэсэг болно.